



БУУДЛАГЫН ТЭМЦЭЭНИЙ ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ



Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулах буудлагын тэмцээн энэ сарын 10-12-ны өдрүүдэд Хужир булан дахь Зэвсэгт хүчний Сургалтын төвд болно. Энэ жилээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит болж байгаа энэхүү

тэмцээнд БХЯ, ЗХЖШ, ЦЕГ, Дотоодын цэргийн штаб, Тагнуулын Ерөнхий газар, ХХЕГ, ОБЕГ зэрэг 12 байгууллагын баг тамирчид оролцоно. ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, орлогч дарга, хурандаа Д.Дугаррагчаа, МТГ-ын зэвсгийн

хэлтсийн дарга, хурандаа П.Чинзориг нар тэмцээний техникийн зөвлөгөөнийг зохион байгуулж, оролцогч багуудын төлөөлөлд тэмцээний дүрэм журам, тамирчдын эрх үүрэг, бэлтгэл, тэмцээний явцад хориглох зүйл зэргийн талаар мэдээлэл өгч, сонирхсон асуултанд нь хариуллаа.

Энэхүү тэмцээний хаалтын ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий Командлагч У.Хүрэлсүх оролцож, Тэргүүн байрын шагналыг гардуулах юм. Мөн энэ үеэр Монголын Зэвсэгт хүчинд нэвтэрч байгаа сүүлийн үеийн зэвсэглэл техникийн үзэсгэлэнг дэлгэн сонирхуулах юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.851.0
EUR	3.385.0	3.400.0
CNY	442.0	443.5
RUB	38.50	39.60
JPY	25.73	26.17
KRW	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.9.7 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 30/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна
Наран ургах, шингэх:
06.18-19.22

Барилдлага:

Арвидах
Шүтэн барилдлага:
Нэр өнгө

Суудал:

Төмөр

Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Цагаан шүүдэр буух улирал (19 цаг 7 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

“ЗАМ 2021” ХАМТАРСАН СУРГАЛТ ЭХЛЭЛЭЭ



Монгол Улсын БХЯ, Япон Улсын БХЯ хооронд байгуулсан хэлэлцээрээр “Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн салбарын чадавхыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийг Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн мэргэжлийн офицер, ахлагч нарыг зам барих аргад сурган дадлагажуулах,

багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэх, мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх, туршлага солилцох зорилгоор Япон Улсын БХЯ-аас боловсруулж, 2014 оноос эхлэн хэрэгжилтийг 12 удаагийн сургалт, дадлагаар хангаад байгаа юм. Дээрх зам сургалт дадлага хамрагдсан бие бүрэлдэхүүн улс орны бүтээн

байгуулалтын ажилд гол цөм нь болж үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь зам сургалтын үр дүнгийн нэгээхэн хэсэг юм.

Харин 2020 оноос эхлэн сургалтын III үеийг 4 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн явуулахаар 2 тал 2019 онд харилцан тохиролцож, төлөвлөсөн

боловч олон улсад тархаад буй цар тахалтай холбогдуулан энэхүү сургалтыг 2020 онд 2 сургалтыг, 2021 оны хаврын сургалтыг, нийт 3 сургалтыг явуулж чадалгүй 3 удаа өнжсөний эцэст 2021 оны намрын сургалтыг эхлүүллээ.

Энэ удаагийн хамтарсан сургалт, дадлага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний зам, барилгын салбаруудын чадавхыг нэмэгдүүлэхээс гадна Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх “Барилга, инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах, тус ротын үндсэн мэргэжилтэн бэлтгэгдэх ач холбогдолтой сургалт, дадлага болох аж.

Түүнчлэн тус хамтарсан сургалт, дадлага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний зам, барилгын салбаруудын чадавхыг нэмэгдүүлэхээс гадна Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх “Барилга, инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах, тус ротын үндсэн мэргэжилтэн бэлтгэгдэх ач холбогдолтой сургалт, дадлага болох юм. Мөн “ЗАМ-2021” хамтарсан сургалт, дадлага нь багш бэлтгэх сургалтад хамрагдсан бие бүрэлдэхүүн сурч мэдсэнээ бодит ажил болгож, дадлага, чадвараа нэмэгдүүлж, зам барилгын ажлыг төлөвлөн зохион байгуулах сэдвийн хүрээнд онолоор зааж сургасан мэдлэгийг практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг олон бүтээлч зүйлсийг төлөвлөн хэрэгжүүлэх юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 237.271	ЭДГЭРСЭН 215,109	НАС БАРСАН 976
+3963	+3560	+8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4715	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 181	ЭДГЭРСЭН 4443
+82	+17	+13

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 221,953,658
Эдгэрсэн Нийт: 198,542,150
Нас барсан Нийт: 4,588,213

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!



ЦЭНГЭ ТӨМӨГ НЭГЭЭЛЭГ ЦЭХЭРЭГ СУРГУУЛД НЬ ГБУУЛАГУЙ ЭМЧНД ЯАРАЛТАЙ ХАНДААРЫ!

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ “ХАМТЫН ХУВЬ ЗАЯА-2021” ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ ЭХЛЭЛЭЭ



Олон улсын энхийг дэмжих ажиллагааны “Хамтын хувь заяа-2021” сургуулийн нээлт 2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр БНХАУ-ын Хэнань мужийн Жумадиан хотод байрлах ХАЧА-ийн Цэргийн төв тойргийн “Куесан” сургалтын баазад зохион байгуулагдлаа. 15-ны өдрүүдэд зохион байгуулагдах

Сургуулийн нээлтийн ажиллагаанд БНХАУ-ын Цэргийн төв зөвлөлийн орлогч дарга бөгөөд ХАЧА-ийн Цэргийн “Төв” тойргийн командлагч дэслэгч генерал Ван Чен Цайя, ХАЧА-ийн орлогч дарга дэслэгч генерал Дэн Жи Пинг тэргүүтэй ХАЧА-ийн албаны зочид болон Хятад, Монгол,

Пакистан, Тайланд Улсын Зэвсэгт хүчний нийт 750 орчим цэргийн алба хаагчид оролцлоо.

Энэ сарын 15-ныг хүртэл зохион байгуулагдах энэхүү олон улсын сургууль нь үүссэн цагийн байдалд энгийн иргэдийг хамгаалах, хүний эрхийн зөрчлийг шалган тогтоох, хүмүүнлэгийн тусалцаа үзүүлэх, гал зогсоох гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны үндсэн мандатаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх сэдвийн дор зохион байгуулагдана. Сургуульд дарга дэслэгч салааны бүрэлдэхүүнээр эрэн хайх, бүслэн нэгжих ажиллагаа, цувааны

хамгаалалт, энгийн иргэдийг хамгаалах, алан хядах ажиллагааны эсрэг сөрөх тусгай ажиллагааны арга тактик, эмнэлгийн татан гаргалт, цар тахлын дэглэм тогтоох, хяналт тавих зэрэг чиглэлээр хэсэгчилсэн болон нэгдсэн сургалт, дадлагад хамрагдах юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж тус олон улсын сургуульд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Нэгдсэн ажиллагааны төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Д.Эрдэнэбилэгээр удирдуулсан 28 цэргийн алба хаагч оролцож байна.

Хурандаа
Д.ЭРДЭНЭБИЛЭГ



“COVID-19” халдварт хамгийн их нэрвэгдсэн орнуудыг нэрлэжээ

АНУ-ын Жонс Хопкинсын нэрэмжит их сургуулийн мэргэжилтнүүд “COVID-19” халдварт хамгийн их нэрвэгдээд буй 20 улс орныг нэрлэжээ. Ингэхдээ дэлхийн улс орнуудад бүртгэгдсэн “COVID-19” халдвараар нас барсан тохиолдлын тоог халдварын батлагдсан тохиолдлын тоо болон хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлтээр нь ангилсан байна.

Тодруулбал, улс

орнуудын халдвараар нас барсан тохиолдлуудыг нь халдварын батлагдсан 100 тохиолдолд болон 100 мянган хүн тутамд харьцуулан тооцоолжээ. Ийнхүү нас барсан тохиолдлын тоог батлагдсан 100 тохиолдол тутамд харьцуулсан үзүүлэлтээр Мексик /7.9 хувь/, Мьянмар /3.8/, Тунис /3.5/, Индонез /3.1/, Өмнөд Африк /3.0/ эхний байруудад бичигджээ.

Харин нас барсан

тохиолдлуудын тоог 100 мянган хүн тутамд харьцуулсан үзүүлэлтээр Бразил /270.87/, Колумби /245.89/, Аргентин /244.00/, Мексик /196.33/, Тунис /190.72/ эхэнд жагссан байна. Ийнхүү харьцуулахдаа нийт хүн амыг хамруулсан бөгөөд батлагдсан тохиолдол, эрүүл иргэдийн аль алийг нь оролцуулжээ.

Эх сурвалж:
ВАШИНГТОН. /Johns Hopkins University/.

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААГЧИД СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА



Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2021 оны “Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэх алба хаагчдын “Цэргийн албаны бэлтгэл” шатны сургалт энэ сарын 6-ны өдрөөс Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулагдаж байна. Сургалтад хамрагдаж байгаа бие бүрэлдэхүүнийг түргэвчилсэн шинжилгээнд бүрэн хамруулж, Улсын Онцгой комиссын заавар, зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахиж, сургалтын хөтөлбөрийн дагуу нийт 96 цагийн турш “Батлан хамгаалах эрх зүй, эх оронч хүмүүжил”, “Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Зэвсэг техникийн бэлтгэл”, “Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэл”, “Цэргийн инженерийн бэлтгэл”, “Биеийн тамирын бэлтгэл” зэрэг хичээлийг судална.

Ахлах дэслэгч
Б.БАТЦЭЦЭГ

АХМАД ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Баянзүрх дүүргийн удирдлагууд Чөлөөлөх дайны түүхт Ялалтын 76 жилийн ойн баярын өдрөөр дүүргийнхээ 1939 оны Халхын гол, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад

хүндэтгэл үзүүлж, дүүргийн “Хүндэт тэмдэг”, үнэ бүхий зүйлийг гардуулан өглөө. Мөн тус дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Амартогтох ахмадуудад Зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны 100, Ардын хувьсгалын 100, Чөлөөлөх дайны ялалтын 76

жилийн ойн мэндийг хүргэсэн юм.

Дашрамд дурдахад, Японы Зэвсэгт хүчний командлал 1945 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр бууж өгөх тухай актад гарын үсэг зурснаар дэлхийн II дайн дууссан өдөр хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг

ФОТО АГШИН



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ